

ШҮД ЭРҮҮ НҮҮРНИЙ ЭМГЭГ СУДЛАЛЫН ТӨВ



ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ

Нэг. БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

Тус эмнэлэг нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1986 оны Стоматологийн поликлиник байгуулах тухай 14 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн яамны сайд, Улаанбаатар хотын Ардын Депутатын Хурлын Гүйцэтгэх Захиргааны 1986 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн / 48/75 / хамтарсан тушаал, тогтоолоор **Стоматологийн Төв Поликлиник** нэртэйгээр шүдний эмнэлэг, оношлогоо, эрдэм шинжилгээний, сургалтын нэгдсэн төв болон зохион байгуулагджээ. Тус Стоматологийн Төв Поликлиник нь дараах бүтэц зохион байгуулалттайгаар ажлаа эхэлсэн байна. Үүнд:

Үндсэн тасаг, кабинетууд

1. Насанд хүрэгчдийн стоматологийн тасаг:
 1. Шүд эмчилгээний кабинет
 2. Парадонтологийн кабинет
 3. Эрүү-нүүрний мэс заслын кабинет
 4. Шүдний согог заслын кабинет
2. Хүүхдийн стоматологийн тасаг :
 1. Шүд эмчилгээний тасаг
 2. Эрүү нүүрний мэс заслын кабинет
 3. Эрүү нүүрний гажиг заслын кабинет
 4. Хэл заслын кабинет
 5. Явуулын бригад
3. Туслах кабинетууд:
 1. Гэрэл
 2. Клиник лаборатори
 3. Регистратур
 4. Ариутгал
 5. Багаж засвар
 6. Статистик
 7. Физик эмчилгээ
 8. Захиргаа аж ахуй, санхүүгийн тасаг

**УЛААНБААТАР ХОТЫН СТОМАТОЛОГИЙН ПОЛИКЛИНИКИЙН
ЭМЧ НАРЫН АЖЛЫН НОРМ**

№	Албан тушаал	Ажлын нийт цаг	Үүнээс үзлэг хийх цаг	Цагт үзэх хүний тоо	Жилд ажиллах өдөр	Жилд үзэх хүний тоо
1	Шүд эмчилгээний	7	6	3	280	5040
2	Эрүү нүүрний мэс засалч	7	6	4	280	6720
3	Протезийн эмч	7	6	2	280	3360
4	Эрүү нүүрний гажиг заслын эмч	7	6	2	280	3360

**АМБУЛАТОРИ, ПОЛИКЛИНИКИЙН ҮНДСЭН
МЭРГЭЖЛИЙН ЭМЧИЙН АЖЛЫН НОРМ**

№	өдөрт ажиллах цаг	Үүнээс		Нэг цагт үзэх хүний тоо		Жилийн ажлын дундаж хоног	Жилд үзэх хүний тоо		
		Амбулатори	Гэрээр	Амбулатори	Гэрээр		Амбулатори	Гэрээр	Үүнээс диспансерийн доод хэмжээ
Шүд	7	5,5	-	3	-	280	4620	-	1300

ТАЙЛБАР:

1. Тусгай тоног төхөөрөмжтэй ажилладаг нарийн мэргэжлийн эмч нарын ажлын нормыг энэ заалтаас 10 хувиар хорогдуулж тооцно.
2. Улсын чанартай зөвлөх поликлиникийн эмчийн нэг цагт үзэх хүний тоог энэ заалтаас нэгээр доогуур тогтооно.
3. Амбулаторийн эмчийн ажлын 1-2 цагийн үзлэг хоорондын завсарлага /нэг цаг тутамд 10 минут/ ариун цэвэр гэгээрлийн ажил, эмч нарын зөвөлгөөн, зохион байгуулалтын ажил, бичиг баримтын ажилд тооцож үзлэгийн цагаас хасаж тооцов.

1986 онд 36 орон тоотой үйл ажиллагаагаа эхэлж, 1987 онд 90, 1988 онд 97, 1989 онд 102 орон тоотой болж өссөн бөгөөд 1986 онд 335,7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байгуулагдаж, 1990 он гэхэд 1 сая 575 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй 104 орон тоотой болж өргөжин, материал техникийн бааз энэ хугацаанд 3 дахин өссөн байна.

Халуун усны системгүй барилгыг анх хүлээн аваад асуудлыг зохих байгууллагуудад танилцуулсны үр дүнд бойлуурын системийг тавиулж эмч, ажилчдын ажиллах боломжийг бүрэн хангасан.

Үүнээс гадна УКТ эмнэлгийн нэгдсэн кабинетын эрүү нүүрний согог заслын кабинетыг орон тоо, тоног төхөөрөмжийн хамт тус поликлиникт шилжүүлснээр 3 үндсэн тасагтай болж эрүү нүүрний эмгэгийг хавсармал эмчилгээгээр анагаах боломжийг бий болгосон.

Поликлиникийн тамга тэмдгийн скизийг гаргаж батлуулснаар хууль зүйн эрхийг хангаж, эмч, ажилчдын дагаж мөрдөх дүрэм, зааврыг боловсруулан дээд байгууллагаар батлуулсан.

Эм, боолтын материал, хиймэл шүдний орцын нормонд хяналт тогтоон төсөвт тусган Поликлиникийн хүчин чадлыг жилээс жилд нэмэгдүүлэх хэтийн төлөвлөгөөг боловсруулан ажилласан ба эмнэлэг үйлчилгээ, аж ахуйн ажиллагаанд хэрэглэх машин болон эмийн сангийн асуудлыг шийдвэрлүүлсэн.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 1997 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 11 дугаар тушаалаар **“Шүд эрүү нүүрний эмгэг судлалын төв”** болон төвийн дүрэм орон тоо нь шинээр батлагдан гарч,

- Нүүр амны эмчилгээ,
- Нүүр амны мэс засал,
- Нүүр амны согог гажиг засал,
- Захиргаа санхүү аж ахуй,
- Урьдчилан сэргийлэх гэсэн 5 үндсэн нэгжтэйгээр нийт 15 кабинетад үзлэг

эмчилгээ хийж үйл ажиллагаа нь өргөжсөн юм.

Нүүр амны мэс заслын тасаг нь Нөхөн сэргээх кабинет, Дүрс оношлогооны кабинет, ариутгалын кабинетаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Тус төвийн анхны захирлаар нүүр амны их эмч Ч.Цэрэндулам 1986-1990 онуудад, их эмч Т.Цэцэгмаа 1990-1994 онд, 1994-1998 онуудад Анагаах ухааны доктор Б.Оюунбат, 1998-2007 онуудад Анагаах ухааны доктор, профессор Н.Пүрэвжав, 2007 оноос одоог хүртэл Анагаах ухааны магистр, Клиникийн профессор Д.Чухал ажиллаж байна.




Шүү эрүү нүүрний эмгэг судлалын төвийн хамт олон /2012 он/

Нүүр амны эмчилгээний тасгийн зөвлөх эмчээр АУИС-ийн багш, тэнхмийн эрхлэгч (тухайн үед) доктор, Монгол улсын хүний гавьяат эмч Ц.Норовпил, Анагаах ухааны доктор Б.Оюунбат, Анагаах ухааны доктор Л.Мөнгөнцэцэг нар, Мэс заслын тасгийн зөвлөх эмчээр АУИС-ийн багш, тэргүүлэх эмч Г.Нацагдорж, Анагаах ухааны доктор Л.Давааням, нүүр амны согог гажиг заслын тасгийн зөвлөх эмчээр Анагаах ухааны доктор, дэд профессор Х.Цолмон, Анагаах ухааны доктор, дэд профессор Б.Амарсайхан, Анагаах ухааны доктор Д.Одончимэг нар ажиллаж байсан ба одоо Анагаах ухааны доктор, профессор Н.Пүрэвжав, Л.Давааням, Б.Оюунцэцэг, их эмч Б.Хишигжаргал нар ажиллаж байна.

Одоо тус төв нь их эмч 23, зөвлөх эмч 4, ерөнхий мэргэжлийн сувилагч 24, шүдний техникч 6, дүрс оношлогооны техникч 2, захиргаа санхүү аж ахуйн 20 ажилтантай, нийт 75 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, жилдээ 120 мянган хүнд шүдний тусламж үйлчилгээ үзүүлдэг, төрөлжсөн нарийн мэргэжлийн төв эмнэлэг юм.

ШЭНЭСТ-ийн 2009-2013 оны 5 жилийн статистик үзүүлэлт



Нийт үзлэгийн 57-60%-ийг 16 хүртлэх насны хүүхэд эзэлж байна.

Үндсэн үйл ажиллагаа нь шүд цоорох өвчин, түүний хүндрэл шүдний тойрон эдийн эмгэг, амны салстын өвчнүүд, цөгцний согог, эгнээний согог бүрэн шүдгүйдэл, эрүү нүүрний томоохон согогууд, хүүхдийн шүдний ургалтын, эгнээний, эрүүний хөгжлийн гажигууд, нүүр амны үрэвсэлт өвчин, гэмтэл, хортой хоргүй хавдар, нүүр амны мэдрэлийн өвчнүүдийг оношлох, эмчлэх, дээрх өвчнүүдээс урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлдэг, мөн амны хөндийн эрүүл ахуйн боловсрол олгодог. Мөн эмнэлэгт

- Чанарын алба,
- Сувилахуйн алба,
- Халдвар хяналтын алба,
- Төгсөлтийн дараах сургалтын албадууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол улсын стандарт хэмжил зүйн албаар Нүүр амны эмчилгээ, оношлогооны хэд хэдэн стандартууд батлагдан гарч, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Төвийн эмч нарын 36 хувь нь боловсролын болон эрдмийн зэрэг цолтой бөгөөд одоогийн байдлаар Клиникийн профессор-2, Анагаах ухааны докторантурт-2, Боловсролын докторантур-1, анагаах ухааны магистр-8, магистрант-4, резидент эмч-1, тэргүүлэх зэргийн эмч 2, ахлах зэрэгтэй эмч 4, бакалавр сувилагч 3, ахлах зэрэгтэй 3 сувилагч ажиллаж байна.

ШЭНЭСТөв нь 162.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, жилдээ 1 тэрбум төгрөгийн төсөвтэй, 200 гаруй боть ном бүхий номын сан, 50 гаруй суудалтай хурлын заал, эмч, ажичдын амрах болон бялдаржуулах өрөөтэй.

2006 онд төвийн 20 жилийн ойд зориулан Шүд эрүү нүүрний эмгэг судлалын төвийн 20 жилийн товчоон ном, 2011 онд Шүд эрүү нүүрний эмгэг судлалын төвийн 25 жилийн ойн “Онол практикийн хурал”-ын илтгэлийн хураангуй, нүүр амны эмгэгүүдийн үед хийгдэх физик эмчилгээний гарын авлага зэргийг хэвлүүлжээ.

Гавьяаны амралтанд байдаг ахмадуудаа “Ахмадын баяр, цагаан сар”-аар жилд 2 удаа байнга хүлээн авч мөнгөн тэтгэлэг олгох, санал хүсэлтийг нь хүлээж авдаг.

Манай эмч, ажилтануудын 75 хувь төрийн болон эрүүл мэндийн салбарын шагналаар шагнагдсан ба “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” цол тэмдгээр-12, Нийслэлийн Эрүүл мэндийн “Тэргүүний ажилтан”-21, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-1, Эрүүл мэндийн яамны “Хүндэт жуух”-11, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын болон Эрүүл мэндийн ажилтаны Үйлдвэрчний холбооны шагналаар-15, Залуучуудын холбооны “Тэргүүний залуу” алтан медаль болон Улаан загалмай, Сувилахуйн шагналаар шагнагдсан тэргүүний эмч, эмнэлгийн ажилчид ажиллаж байна.



ШЭНЭСТөвийн Захирлын зөвлөл /2012 он/

Стоматологийн поликлиник анх байгуулагдсан цагаас одоог хүртэл болон тогтвор суурьшилтай ажиллаж байгаа манай анхны эмч, Нүүр амны эмчилгээний тасгийн эрхлэгч Ж.Энхтуяа, шүдний техникч Д.Тэрбиш, Захирал, Клиникийн профессор Д.Чухал, шүдний техникч Ц.Наранцэцэг, Ц.Оюунчимэг, П.Мядаг, сувилагч М.Энхтайван, Ж.Алтантуяа, болон Тэргүүлэх зэргийн их эмч, Нүүр амны мэс заслын тасгийн эрхлэгч Ч.Итгэлт, Нүүр амны их эмч Д.Гиймаа, Э.Батцэцэг, Л.Өнөржаргал

зэрэг тэргүүний эмч, ажилтнуудаараа болон ажилсаг, нөхөрсөг хамт олноороо бид бахархдаг юм.

Одоо тус төвийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, Ахлах зэргийн эмч Р.Эрдэнэчулуун, Ахлах нягтлан бодогч Б.Сэргэлэн, Нягтлан бодогч Б.Баянжаргал, Хүний нөөцийн менежер Д.Сансар, Сувилахуйн албаны дарга Гэрлийн техникч Б.Уранбилэг, Халдвар хяналтын албаны дарга М.Энхтайван, Архив, бичиг хэргийн эрхлэгчээр Г.Улзмаа, Нүүр амны согог гажиг заслын тасгийн эрхлэгчээр Т.Уянга, Эмийн нярав Л.Оюунчимэг, Аж ахуйн нярав Д.Эрдэнэцэцэг, ахлах касс Н.Уянга нар ажиллаж байна.

**Хоёр. ШҮД ЭРҮҮ НҮҮРНИЙ ЭМГЭГ СУДЛАЛЫН ТӨВИЙН
ОРОН ТОО**

№	Албан тушаалын ангилал	Ажиллаж буй орон тоо
1	Захирал	1
2	Чанарын менежер	1
3	Ерөнхий нягтлан бодогч	1
4	Тооцооны нягтлан бодогч	1
5	Архив, бичиг хэргийн эрхлэгч	1
6	Хүний нөөцийн менежер /Статистикч эмч/	1
7	Их эмч	21
8	Сувилагч	21
9	Рентген техникч	2
10	Шүдний техникч	6
11	Физик эмчилгээний сувилагч	1
12	Ариутгагч сувилагч	2
13	Кассын нярав, /Эмийн нярав/	1
14	Аж ахуйн нярав	1
15	Эм зүйч	1
16	Ариутгалын туслах ажилтан	
17	Чанарын лавлагаа үйлчилгээний ажилтан	
18	Касс зохицуулагч	2
19	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер	1
20	Ресепшин буюу хөтөч операторч	1
21	Слесарь	
22	Жижүүр	3
23	Үйлчлэгч	4
24	Хувцас олгогч	2
25	Асрагч	1
Дүн		75

ШЭНЭСТөв нь Монгол Улсын Эрүүл Мэндийн яамны 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 263 дугаар батламжаар 3 жилийн хугацаагаар, 2005 оны 263 дугаар батламжаар 5 жилийн хугацаагаар “Магадлан итгэмжлэгдсэн эмнэлэг” болсон.

Тус төвийн төгсөлтийн дараах сургалтын алба нь Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2001 оны 182/229 дугаар тушаалын үндэслэн олгосон 57 тоот гэрчилгээ бүхий зөвшөөрлөөр Нүүр амны согог засалч эмчийн резидентурын 2 жилийн сургалт, нүүр амны эмчилгээний эмч, нүүр амны мэс засалч эмчийн мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалт, НАЭ-ний сувилагчийн болон шүдний техникчийн мэргэжил олгох 3 сарын сургалтуудыг 2003 оноос эхлэн явуулж одоогийн байдлаар 24 суралцагч амжилттай төгсөн ажиллаж байна. Тус төв нь төгсөлтийн дараах сургалтыг резидентурын, богино хугацааны дотоодын болон гадаадын сургалт гэсэн 3 хэлбэрээр явуулдаг.

Манай сургалтын давуу тал нь батлагдсан сургалтын стандарт хөтөлбөрөөр жинхэнэ практик дээр өвчтөнд суурилсан сургалт явуулдаг бөгөөд нэг суралцагч эмчид гарын дадлагын материал тавьж олгон дадлага хийх бололцоо нөхцлийг хангаж ажилладаг.

Сургалт явуулдаг багш нарын 80 хувь нь эрдмийн зэрэг цолтой бөгөөд Япон, Куба, ОХУ, Солонгос улсад мэргэжил дээшлүүлсэн, мэргэжлээрээ олон жил ажилласан дадлага туршлагатай эмч, багш нар сургалт явуулдаг юм. “Мастер дент”, “Энхийн мишээл”, “Хаш-дент” зэрэг шүдний эмнэлгүүдийг түшиглэн дадлагын хичээлийг тойрон графикаар явуулж дадлага туршлагатай эмч нарыг дагалдуулан сургаж байна. Төгсөлтийн дараах сургалтын албаны даргаар 2002-2005 онд Г.Ганжаргал, Д.Чухал, нар ажиллаж одоо эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, чанарын албаны дарга Р.Эрдэнэчулуун ажиллаж байна.

Тус эмнэлгийн барилгыг өргөтгөх төслийг боловсруулж эмчилгээ үйлчилгээний хүрээг тэлж, жилд 250-300,0 мянган хүнд төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламжийг дэлхийн түвшинд үзүүлж эрүү ясанд нь шүд суулгадаг, эрүү нүүрний мэс заслын хэвтэн үйлчлүүлдэг тасагтай болгож тус эмнэлэг нь өөрөө эмч, сувилагч, дунд мэргэжилтнүүдийн давтан сургалтыг зохион байгуулж явуулдаг болох зэрэг олон улсын жишигт нийцсэн төв эмнэлгийг бий болгож ажиллуулахаар зорьж байна.

Гурав. Хөмрөгийн түүх

Шүд, эрүү нүүрний эмгэг судлалын төвийн архивын баримтанд анх эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг 2004 оны 02 дугаар сарын 16-наас 02 дугаар сарын 28-ны хооронд архивч Ц.Цэцэгмаа хийж гүйцэтгэн байнга хадгалагдах 1986-2003 оны 58 ХН, түр хадгалагдах 1995-2003 оны 104 ХН, 70 жил хадгалагдах 1986-1994 оны 18 ХН, устгах хэргийн акт 1986-1994 оны 21 хэргийн 580 кг ХН бүхий данс бүртгэлийг үйлдэн төрийн архивт 130 дугаар хөмрөгийг үүсгэсэн байна.

Тус байгууллага нь 2014 онд 2004-2013 оны байнгын баримтаар Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийн дагуу Архив, бичиг хэргийн эрхлэгч Г.Улзмаа нь Нийслэлийн Архивын газрын Зааварлагч-арга зүйч н.Жүгдэрнамжилаас мэргэжил арга зүйн зааварчилгаа аван байгууллагын архивт хадгалагдаж буй 1986-2013 оны нийт 600 гаруй баримтад 2014 оны 02 дугаар сарын 01-нөөс 2014 оны 04 дүгээр сарын 01-нийг дуустал хугацаанд эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

2004-2013 оны байнга хадгалах 169 хадгаламж, 1986-2013 оны 70 жил хадгалах 70 хадгаламжийн нэгжийг дугаарлан бүртгэл үйлдэв. 2004-2013 оны түр хадгалах 892 хадгаламжийн нэгжийн хадгалах хугацааг нягтлан шалгаж, данс бүртгэл үйлдэн, нягтлан шалгалт хийн он тус бүр дээр ач холбогдлоор нь ангилан ялгаж бүртгэл үйлдсэн. 1997-2011 оны устгах баримтуудыг нягтлан шалгаж хадгалах хугацаа дууссан, түүх, эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 22 хэргийн 172 ХН-д устгах хэргийн акт үйлдсэн. 2004-2013 оны нийт 1131 баримтанд бүртгэл үйлдсэн байна.

Баримтын бүрдэл:

- Байнга хадгалагдах баримтын бүрдлийн хувьд:

Дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт,
Захирлын тушаал, хурлын тэмдэглэл,
Нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилт,
Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ, биелэлт,
“Амны хөндийн эрүүл мэнд” дэд хөтөлбөр, хөтөлбөрийн хэрэгжилт,
Захиргаа, ҮЭ-ийн хамтын гэрээ,

Төвийн жилийн ажлын төлөвлөгөө, биелэлт,
Төвийн жилийн ажлын тайлан,
Үйл ажиллагааны статистик тайлан,
Эмийн тендерийн баримт,
Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, стандарт,
Диспансерийн хяналтын карт,
Алба, тасгийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан,
Санхүүгийн жилийн эцсийн тайлан,
Төсвийн гүйцэтгэл,
Татварын тайлан,

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан зэрэг баримтуудаас бүрдэж байна.

-70 жил хадгалагдах баримтын бүрдлийн хувьд:

Боловсон хүчинтэй холбогдолтой тушаал,
Цалингийн тооцооны хүснэгт,
Цалингийн карт,

Нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооны хуудас зэрэг баримтуудаас бүрдэж байна.

-Түр хадгалагдах баримтын бүрдлийн хувьд:

Ирсэн бичиг,

Явуулсан бичиг,

Бүртгэлийн дэвтрүүд,

Ажилчдын үр дүнгийн гэрээ, биелэлт,

Алба, тасгийн улирал, хагас жилийн төлөвлөгөө, тайлан

Кассын баримт

Кассын орлогын баримт

Харилцахын баримт

Эмчийн үзлэгийн бүртгэл,

Хагалгааны зөвшөөрлийн хуудас,

Нүүр амны эмчилгээний тайлан,

Техникч нарын тооцооны хуудас,

Жижүүр эмчийн орлогын баримт,

Эрүүл мэндийн даатгалын нэхэмжлэх,

Эмийн тайлан

Аж ахуйн тайлан,

Бүртгэл хяналтын карт,

Ажилд орох хүсэлт гаргасан хүмүүсийн баримт бичиг,

Ажлаас чөлөөлөгдсөн хүмүүсийн тойрох хуудас зэрэг баримтуудаас бүрдэж

байна.

Байгууллагын архивт хадгалагдаж байсан 1986-2013 оны хадгаламжийн нэгжүүдэд эрдэм шинжилгээ техник боловсруулалтыг ажлыг хийснээр:

- 2004-2009 оны 1-97 дугаартай 97 хадгаламжийн нэгж бүхий байнга хадгалах данс,
- 2010-2013 оны 98-169 дугаартай 169 хадгаламжийн нэгж бүхий байнга хадгалах данс,
- 1998-2013 оны 892 хадгаламжийн нэгж бүхий түрийн бүртгэл,
- 1986-2013 оны 70 хадгаламжийн нэгжийн 70 жилийн бүртгэл,
- 2006-2012 оны 2 хадгаламжийн нэгж бүхий дүрс бичлэгийн баримтын бүртгэл,
- 2005-2008 оны эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 22 нэр төрлийн 172 хадгаламжийн нэгжийг устгах устгах хэргийн актыг тус тус үйлдсэн байна.